

БАТЛАВ
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Р.СЭДДОРЖ

2023 оны ... дүгээр сарын ...-ны өдөр

УДИРДАМЖ

2023 оны 04 дүгээр сарын 25

Даланзадгад

**"ЦАГ ГАРГАЯ" АЯНЫ ХҮРЭЭНД ДУГУЙН УРАЛДААНТ
АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ**

ҮНДЭСЛЭЛ: Дэлхийд хүн амын нас баралтын 6% нь хөдөлгөөний хомсдолоос хамааралтай байна. Хөдөлгөөний идэвхгүй байдал нь зүрх судасны өвчин, чихрийн шижин хэв шинж, хавдар, таргалалт зэрэг халдварт бус өвчнийг нэмэгдүүлж жилд дунджаар 3.2 сая хүн хөдөлгөөний дутагдлаас үүдэлтэй өвчлөлөөр нас барж байна. Дэлхий нийтээр тархаж буй "Ковид-19" цар тахлын дэгдэлт, олон нийтийн хөл хорионы улмаас хүн амын идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх нөхцөл боломж буурч хөдөлгөөний хомсдолд өртөх магадлал өсөн нэмэгдэж байна. Монгол улсын 15-69 насны хүн амын 21.9% нь хөдөлгөөний хомсдолтой, 52.4% нь ажлын байрандаа, 48.2% нь амралт чөлөөт цагаараа идэвхтэй хөдөлгөөн хийдэггүй гэдгийг ХБӨ, осол гэмтлийн шалтгаан эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг тогтоох үндэсний 4-р судалгаанд дурджээ.

Хүн амын 49,4% илүүдэл жин ба таргалттай, 30.9% нь илүүдэл жинтэй 18.5% нь таргалттай байна. Эмэгтэйчүүдийн дунд таргалалтын тархалт эрэгтэйчүүдээс харьцангуй илүү, таргалалтын түвшин нас ахих тусам нэмэгдэх хандлагатай байна.

Судалгаанаас харахад хүн амын дунд хөдөлгөөний идэвхгүй зан үйлтэй байх нь залуужиж байгаа бөгөөд чөлөөт цагаараа зориуд дасгал хөдөлгөөн хийхээс илүүтэйгээр хүн амын дунд дугуй унах, алхах, газар тариалан дээрээ ажиллах зэрэг идэвхтэй хэв маяг нь нэмэгдэж байна. Залуучуудын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин 18.2 хувь нь 7 хоногт сургууль гэр хоёрын хооронд явган эсвэл дугуйгаар явдаггүй. Хоёр хүүхэд тутмын нэг буюу 44.3 хувь нь зурагт үзэх, компьютер тоглох, суух, найзтайгаа ярих зэрэг идэвхгүй байдалд өдөрт 3 ба түүнээс олон цагийг зарцуулдаг байна. Манай улсад 6-17 насны хүүхэд, өсвөр үеийнхний 3 хүүхэд тутмын 1 буюу 32,9 хувь нь бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшнээр дунд, хангалтгүй (D,F) үнэлгээтэй байна.

Иймээс нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, идэвхтэй хөдөлгөөний ач холбогдлыг хүн амд сурталчлах, хэвшүүлэх, чийрэгжүүлэх, дасгал хөдөлгөөнийг тэдний амьдралын дадал хэвшил болгох төрийн албан хаагчдын идэвхтэй хөдөлгөөний ач холбогдлын талаар сурталчлах, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх таатай орчныг бүрдүүлэх зэрэг асуудлуудыг нэн тэргүүнд шийдвэрлэн, дэмжиж ажиллах шаардлага хэрэгцээ байна.

Зорилго: Хүн амыг хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх, тогтмол идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээлэх эрүүл зан үйл, хандлага төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Зорилт:

1. Хүн амын дунд дугуй унах соёлыг төлөвшүүлэх, бүх нийтээрээ нийтийн биеийн тамирыг дэмжсэн, эрүүл аймаг сум болох хөдөлгөөнийг өрнүүлэх.
2. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн албан хаагч, иргэдэд идэвхтэй дасгал хөдөлгөөн, дугуй унахын ач холбогдлыг сурталчлах, уриалах.

Хамрах хүрээ: Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж

Зохион байгуулагч:

- Аймгийн Засаг Даргын тамгын газар
- Эрүүл мэндийн газар
- Биеийн тамир спортын газар

Хэрэгжүүлэх хугацаа:

2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдөр

Хүлээгдэж буй үр дүн:

- Иргэдийн дунд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, нийтийн биеийн тамираар хичээллүүлж эрүүл мэндийг бэхжүүлэх, эдийн засагт хэмнэлт хийх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, байгаль орчны бохирдлыг бууруулах, автозамын түгжрэлийг бууруулах, унадаг дугуйн хэрэглээг нэмэгдүүлэх, дугуйн соёлыг сурталчилахад чухал ач холбогдолтой.
- Амралтын өдрүүдэд байгууллага хамт олноороо дугуйн аялал зохион байгуулж бие бялдраа чийрэгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэхэд чиглэсэн олон талт арга хэмжээ зохион байгуулахыг уриалж дэмжинэ.
- Аймгийн хэмжээнд дугуй унах соёлыг төлөвшүүлэх, бүх нийтээрээ нийтийн биеийн тамирыг дэмжсэн, эрүүл аймаг сум болох хөдөлгөөнийг үр дүнтэй эхлүүлсэн байна.
- Ард иргэдийг чийрэгжүүлэх, дасгал хөдөлгөөнийг тэдний амьдралын дадал хэвшил болгох хүүхэд, залууст идэвхтэй хөдөлгөөний ач холбогдлын талаар сурталчлах, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх таатай орчныг бүрдүүлнэ.

Зохион байгуулах үйл ажиллагаа:


1. Хүн амын дунд дугуй унах соёлыг төлөвшүүлэх, бүх нийтээрээ нийтийн биеийн тамирыг дэмжсэн, эрүүл аймаг сум болох хөдөлгөөнийг өрнүүлэх.
2. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн албан хаагч, иргэдэд идэвхтэй дасгал хөдөлгөөн, дугуй унахын ач холбогдолыг сурталчлах, уриалах, зэрэг нөлөөллийн арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа дамжуулан зохион байгуулах.
3. Албан байгууллага аж ахуйн нэгжээрээ зун, намрын улиралд дугуйгаар зорчих, дугуйгаар ажилдаа явах дадлыг хэвшүүлэх
4. Дугуйгаар ажилдаа зорчиж буй байгууллага, албан хаагчдыг дэмжих, урамшуулах, олон нийтэд сурталчлах
5. Аймгийн хэмжээнд албан байгууллага аж, ахуй нэгжүүд байгууллагын дотоод журамд ажилдаа ирэх, буцахдаа автомашинаас татгалзан тогтмол дугуй унаж буй албан хаагчдыг урамшуулах боломж нөхцөлийг тусгах.
6. Байгууллага бүр идэвхтэй дасгал хөдөлгөөн хийж буй дадал хэвшлээ олон нийтэд сурталчлах, уриалах зэрэг нөлөөллийн арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа дамжуулан зохион байгуулах.
7. Дугуйгаар ажилдаа явах хөдөлгөөний олон нийтэд уриалсан, дотооддоо амжилттай нэвтрүүлж тогтмол хийж хэвшсэн байгууллага аж ахуй нэгжийг шалгаруулах, олон нийтэд сурталчлах.


Шалгаруулж дүгнэх үйл ажиллагаа:

- Зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан мэдээг баталгаажуулан Эрүүл мэндийн газарт 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Эрүүл мэндийн газарт ирүүлсэн байна.

- Байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн баг ирүүлсэн тайлантай танилцаж, шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ өгнө.
- Аяны үйл ажиллагаанд амжилттай оролцсон албан байгууллага, аж ахуй нэгжийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчилна.
- Аяны удирдамжид тусгасан үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж ажилласан сум, баг, албан байгууллага, аж ахуй нэгжийг шагнаж урамшуулна.

Шалгаруулах байр	Тоо хэмжээ	Мөнгөн шагнал
Шилдэг сум		
1 дүгээр байр	1	1.000.000
2 дугаар байр	1	700.000
3 дугаар байр	1	500.000
Шилдэг албан байгууллага, аж ахуй нэгж		
1 дүгээр байр	1	1.000.000
2 дугаар байр	1	700.000
3 дугаар байр	1	500.000
Идэвхтэй оролцсон иргэн		
5 иргэн	1	300.000
	1	300.000
	1	300.000
	1	300.000
	1	300.000

ХЯНАСАН:
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  Ц.БАДАМЦЭРЭН

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН  Э.МЯГМАРСҮРЭН